



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан Уул аймгийн "Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/2/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Дархан Уул аймаг, Дархан сум 2025 он	Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
4. Аудитын тайлан	12
4.1. Ерөнхий зүйл.....	12
4.2. Материаллаг байдал	12
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. Аудитын илрүүлэлт	14
Залруулга.....	14
5.1 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3069, Факс: (976) 7037-3069
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.19 № 170

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ нь тайлант онд 1,088,392.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 692,767.2 мянган төгрөгийн зардал гарган 395,625.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. "Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны жилийн үйл

4525020200

ажиллагааны төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 96.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	751,859,569.51	782,515,709.75
1.1.2	Дансны авлага	20,875,502.54	233,061,987.46
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	6,961,023.37	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	7,052,550.52	9,187,096.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	0.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	786,548,645.94	1,024,764,793.37
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	74,278,473.01	84,390,136.86
1.2.2	Биет бус хөрөнгө	2,386,363.66	1,590,909.06
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	76,664,836.67	85,981,045.92
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	863,213,482.61	1,110,745,839.29
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	Өр төлбөр	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	0.00	0.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	70,392,239.26	51,022,827.14
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	121,506,190.00	84,675,573.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	191,898,429.26	135,698,400.14
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5		0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	191,898,429.26	135,698,400.14
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч - төрийн	18,193,545.00	18,193,545.00
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	21,458,827.00	23,649,623.20
2.3.9	Хүримтлагдсан ашиг	631,662,681.35	933,204,270.95
2.3.11	Эздийн өмчийн дүн	671,315,053.35	975,047,439.15
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	863,213,482.61	1,110,745,839.29

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мерийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,120,524,144.87	1,025,750,284.92
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	1,120,524,144.87	1,025,750,284.92
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	7,169,070.91	9,856,274.90
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	22,100,806.57	52,786,232.46
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	559,585,286.05	656,306,954.16
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(19,800,000.00)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	590,208,736.3	412,285,838.12
19	Орлогын татварын зардал	568,107,92.98	16,660,280.12
20	Татварын дараах ашиг (алдагдал)	533,397,943.32	395,625,558.00
21	Үндсэн хөрөнгө худалдсаны олз (гарз)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	533,397,943.32	395,625,558.00
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	1,149,794,022.35	1,088,392,792.28
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	233,271,616.03	272,923,988.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	233,271,616.03	272,923,988.03
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	533,397,943.32	533,397,943.32
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00

7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	(135,006,878.00)	(135,006,878.00)
9	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	631,662,681.35	671,315,053.35
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	631,662,681.35	671,315,053.35
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	395,625,558.00	395,625,558.00
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	2,190,796.20	0.00	2,190,796.20
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	(94,083,969.00)	(94,083,969.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	18,193,545.00	23,649,623.20	933,204,270.95	975,047,439.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,244,907,518.93	968,154,151.87
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,223,216,712.36	916,348,828.50
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	778,650.30	675,609.70
1.1.4	Буцаан авсан албан татвар	20,862,156.27	51,129,713.67
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	50,000.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	697,560,177.43	770,708,096.53
1.2.1	Ажиллагчдад төлсөн	186,548,582.00	355,981,275.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,407,697.96	91,926,772.78
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	20,929,000.00	17,070,017.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	8,527,085.53	8,412,688.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,759,650.00	19,567,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	151,311,477.62	162,581,432.75
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	269,076,684.32	115,168,911.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	547,347,341.50	197,446,055.34
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,169,070.91	9,856,274.90
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон эзэл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	7,169,070.91	9,856,274.90
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00

2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	39,429,900.00	54,940,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	35,929,900.00	54,940,000.00
2.2.2	Биеет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,500,000.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,260,829.09)	(45,083,725.10)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	(121,506,190.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	121,506,190.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	121,506,190.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(121,506,190.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	515,086,512.41	30,856,140.24
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	236,573,057.10	751,659,569.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	751,659,569.51	782,515,709.75

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
2	Нийт орлого	1,149,794,022.35	950,000,000.00	1,088,392,792.28	138,392,792.28	114.57
	Үүнээс: Цэвэр борлуулалт	1,120,524,144.87	950,000,000.00	1,025,750,284.92	75,750,284.92	107.97
	Бусад орлого	29,269,877.48	0.00	62,642,507.36	62,642,507.36	0.00
3	Нийт зардал	0.00	0.00	0.00	0.00	0.00
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00	0.00	0.00	0.00
	б) Ерөнхий удирдлагын зардал	616,396,079.03	950,000,000.00	672,967,234.28	(277,032,765.72)	70.84
	в) Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз	0.00	0.00	(19,800,000.00)	0.00	0.00
4	Цэвэр ашиг, алдагдал	533,397,943.32	0.00	395,625,556.00	415,425,558.00	0.00

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ нь "Төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг ханган, хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх" гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын дүрэмд Дархан-уул аймаг болон сумдад хэрэгжүүлж буй улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, гадаадын болон зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй барилга угсралт, авто зам, инженерийн шугам сүлжээний төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Барилга байгууламжийн төлөв байдлыг үнэлэх, бат бөх чанарыг тооцоолох, норм дүрмийн шаардлагыг хангах
- Барилгыг зураг төслийн дагуу угсарч барих ажлыг удирдан зохион байгуулах, инженерийн хяналт тавих
- Материал, тоног төхөөрөмж, ажиллах хүчний тоо хэмжээ, үнэ өртгийг тооцоолон төслийн бодит хэрэгжих боломжийг тооцоолох
- Барилга угсралтын явц, төлөвлөгөөний биелэлт болон материал бүтээц, эдлэхүүний чанар, хийцэд зураг, төсөв, барилгын норм, дүрэм стандарт, техникийн нөхцөлийн дагуу хяналт тавих
- Барилга угсралтын явцад үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэх, гарсан доголдлын шалтгааныг судалж тодорхойлох, сэргийлэх арга хэмжээ авах
- Барилгын материал бүтээц, эдлэхүүнийг шаардлагатай тохиолдолд сайжруулах солих, хийцийн шийдэлд өөрчлөлт оруулах
- Байгууллагын удирдлагыг мэргэжлийн түвшинд барилга угсралтын явц болон төлөвлөгөө тайлангаар хангах
- Барьж дуусгасан барилга байгууламжийг техникийн комисст хүлээлгэн өгөх, холбогдох бичиг баримтыг бэлтгэх, гүйцэтгэлийн үе шатны хуваарийн дагуу хянан баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны 04 сарын 01-ний өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А52 дугаар тушаал;
- Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоол;

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын мөрдөж буй "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 247,532.4 мянган төгрөгөөр буюу 28.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	751,659.6	782,515.7	30,856.1
Авлага	27,836.5	233,062.0	205,225.5
Бараа материал	7,052.6	9,187.1	2,134.5
Үндсэн хөрөнгө	76,664.8	85,981.0	9,316.2
Нийт хөрөнгө	863,213.5	1,110,745.8	247,532.4
Богино хугацаат өр төлбөр	191,898.4	135,698.4	(56,200.0)
Эздийн өмчийн дүн	671,315.1	975,047.4	303,732.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	863,213.5	1,110,745.8	247,532.4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 782,515.7 мянган төгрөг болж 30,856.1 мянган төгрөгөөр өссөн нь 968,154.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 937,298.0 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 233,062.0 мянган төгрөг болж 205,225.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны хөрөнгө оруулалтын гэрээт ажлын авлага 205,225.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,187.1 мянган төгрөг болж 2,134.5 мянган төгрөгөөр өссөн нь 35,110.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 32,976.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,316.2 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 49,945.5 мянган

төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 12 сарын 02 өдрийн А/35 тоот тушаалаар 2,190.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тавилга эд хогшилыг ашиглах хугацааг сунган, үнийг шинэчлэн тогтоож орлогоор авсан, мөн Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газарт 19,800.0 мянган төгрөгийн автомашиныг Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчидийн хурлын 2024 оны 4 дүгээр сарын 26 өдрийн тогтоолоор шилжүүлсэн, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 07-р сарын 03-ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 9,751.2 мянган төгрөгийн хөрөнгийг актаж, тайлант хугацаанд 25,224.6 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 56,200.0 мянган төгрөгөөр буурсан нь 2023 оны 121,506.2 мянган төгрөгийн ноогдол ашгийг шилжүүлсэн, 2024 онд 84,675.6 мянган ноогдол ашгийг тооцож өглөгөөр бүртгэсэн, аж ахуйн нэгжийн орлогын татварын өглөг 16,660.3 мянган төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 24,803.2 мянган төгрөг, бусад татварын өглөг 9,559.3 мянган төгрөг болж тус тус буурсантай холбоотой байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 303,732.4 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу "Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг орон нутгийн өмчийн газар болон аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс хянаж, Засаг дарга баталсан байна.

Тайлант онд нийт орлогыг 950,000.0 мянган төгрөгөөр, нийт үйл ажиллагааны зардлыг 950,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2 зорилтын хүрээнд 12 төсөл, арга хэмжээнээс 916,348.8 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 51,805.3 мянган төгрөг, нийт 968,154.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 937,297.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,088,392.8 мянган төгрөг болж төлөвлөгөөг 138,392.8 мянган төгрөг буюу 114.6 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 395,625.5 мянган төгрөг болсон нь 2023 оноос эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээнд хяналт тавьсантай холбоотой байна.

Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчийн тогтоолоор баталсан орон нутгийн өмчит газрын дүрмийн 5 дахь бүлгийн 5.9 дэх "Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас 25 хүртэл хувийг ногдол ашиг хэлбэрээр аймгийн төсөвт төвлөрүүлнэ" гэсэн заалтын дагуу 84,675.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцоолон санхүүгийн тайланд өглөгөөр тусгасан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлыг харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу "Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд байгууллагын татварын тодорхойлолтоор татварын төрөл бүрээр илүү төлөлттэй байгааг хянаж, татварын байгууллагатай тооцоо хийж үлдэгдлийг залруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг "Пийк Ом Аудит" ХХК-д 2025 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан зорилтот түвшний нийт зардлын дүн 950,000.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19,000.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовн дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд алдаа зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Хөдөлмөрийн тухай хууль, дотоод дүрэм, журмын хэрэгжилтийн талаар.

Илрүүлэлт: Тайлант онд тус байгууллагын бүтэц орон тооны дутагдалтай ажиллаж байгаагаас ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг ажилтанд биеэр эдлүүлээгүй, нөхөн амраагаагүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, байгууллагын дотоод үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа хууль тогтоомжийн хүрээнд дүрэм журмыг шинэчлэн боловсруулж ажиллах зөвлөмж өглөө.

2. Хууль тогтоомж, НБББББ-н хэрэгжилтийн талаар.

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт, шинэчлэлтийг хийгээгүй, санхүүгийн программ хангамжтай уялдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөн ажиллана" гэж заасантай нийцэхгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж, цаашид алдаа зөрчил давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өглөө.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,516.8 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	1,516.8	3	1,516.8	100.0
Нийт дүн	3	1,516.8	3	1,516.8	100.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. Аудитын илрүүлэлт

Залруулга

Аудитын явцад дараах алдааг залруулсан. Үүнд:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 2,190.8 мянган төгрөгийн алдаануудыг залрууллаа. Үүнд:

Ашиглах хугацаа сунгаж үнэ шинэчлэн тогтоосон 2,190.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байгаа нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", "Иж бүрэн байх", "Толилуулга", "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулав.

Аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлаас бусад алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар албан зөвлөмж зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны тооч утга	Нийт алдаа		Үүнээс	Зөвлөмж
-------------------	------------	--	--------	---------

			Мэдээллийг туслахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ашиглах хугацаа сунгам үнэ шинэчлэн трэгтоосон тэрэг төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй.	1	2,190.8	1	2,190.8			1	2,190.8				
	1	2,190.8	1	2,190.8	0	0	1	2,190.8	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитлаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/манган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Наттлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт, шинэчлэлийг хийгээгүй, санхүүгийн программ хангамжтай уялдуулаагүй..	1	0.00					1	0.00
Тус байгууллага бүтэц орон тооны дутагдалтай ажиллаж байгаагаас ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг ажилтанд биеэр эдлүүлээгүй, нөхөн амраагаагүй байна.	1	0.00					1	0.00
Дүн								
Нийт дүн	2	0.00					2	0.00

